



1. Албадан дуудлага худалдаанд оруулах үнийг оролцогчид харилцан тохиролцон тогтоохоор хуульчилсан байдаг. Гэтэл зарим төлбөртөлөгч нар үнийн санал өгөхөөс санаатайгаар зайлсхийж, шинжээчийн үнэлгээнд гомдол гарган шийдвэр гүйцэтгэх ажиллагаанд чирэгдэл учруулдаг. Төлбөр авагч, төлбөр төлөгч нар заавал харилцан тохиролцож албадан дуудлага худалдаанд оруулах үнийг тогтооно. Хэрэв тохиролцохгүй бол хөндлөнгийн шинжээчийг томилно. Хөндлөнгийн шинжээчийн тогтоосон үнэлгээнд гомдол гаргах эрхгүй байхаар хуульд нэмэлт өөрчлөлт оруулах,
2. Иргэний хуулийг төсөөтэй хэрэглэж болох заалтыг баримтлан “Үл хөдлөх эд хөрөнгийн барьцааны тухай” хуулийн холбогдох зүйл, заалтыг удирдлага болгон албадан дуудлага худалдааг явуулах,
3. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд заасан “...сүүлийн үнэ хэлэхийг зарласан үе сүүлийн үнийн санал хоёрын хооронд 30 минут байх...” заалтыг хасах эсхүл хугацааг богиносгохоор өөрчлөлт оруулах шаардлагатай байна



С.БУЯНЗАЯА
Хууль сахиулахын
их сургуулийн
Шүүхийн шийдвэр
гүйцэтгэлийн
Шүүхийн шийдвэр
гүйцэтгэлийн
процессын эрх зүйн
тэнхимийн багш,
ахлах дэслэгч

ГЭМТ ХЭРГИЙН ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСӨЛД ТУСГАГДСАН ХОРИХООС ӨӨР ТӨРЛИЙН ЯЛ ЭДЛҮҮЛЭХ АЖИЛЛАГААНД ТАВИХ ХЯНАЛТ

Шинэчлэлийн Засгийн газраас баримталж буй эрх зүйн салбарын шинэтгэлийн бодлоготой уялдуулан шинээр хэлэлцэгдэж буй Гэмт хэргийн тухай хуулийн төсөлд тусгагдсан хорихоос өөр төрлийн ял эдлүүлэх ажиллагаанд тавих хяналттай холбоотой шийдвэрлэвэл зохих асуудлыг хөндөн үзэж тодорхой үндэслэл бүхий санал дэвшүүлэхийг зорилгоо болгон энэхүү илтгэлийг хэлэлцүүлж байгаадаа таатай байна.

Илтгэлийн агуулгыг хорихоос өөр төрлийн ял эдлүүлэх ажиллагаанд хяналт тавьж буй өнөөгийн байдал, гэмт хэргийн тухай хуулийн төсөлд тусгагдсан хорихоос өөр төрлийн ялын эрх зүйн зохицуулалт, ял эдлүүлэх ажиллагаанд тавих хяналтын асуудлыг боловсронгуй болгох гэсэн хоёр хэсгээр томъёоллоо.

Өнөөдөр хүчин төгөлдөр мөрдөгдөж буй Эрүүгийн хуулинд 7 төрлийн ялтай байхаар эрх зүйн зохицуулалт хийсэн байдаг. Үүнээс хорихоос өөр төрлийн



ял нь 6 байгаа бөгөөд түүний 2 төрөл буюу баривчлах, цаазаар авах ялыг Тогтоол гүйцэтгэх газар, бусад 4 төрөл буюу торгох, албадан ажил хийлгэх, эд хөрөнгө хураах, тодорхой албан тушаал эрхлэх, үйл ажиллагаа явуулах эрхийг хасах ялыг Шийдвэр гүйцэтгэх газар хариуцан ял эдлүүлэх ажиллагааг хэрэгжүүлж байна.

Эдгээр ял эдлүүлэх ажиллагааг Эрүүгийн хууль, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль болон бусад холбогдох хуулиуд, тэдгээрт нийцүүлэн гаргасан бусад эрх зүйн актуудаар зохицуулж байна.

Бүхий л төрлийн ял эдлүүлэх ажиллагаанд Прокурорын байгууллагын тухай хуульд заасны дагуу прокурор хяналт тавин зарим төрлийн ял эдлүүлэх ажиллагаанд цагдаагийн байгууллагатай хамтран хяналт тавихаар Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд тусгагдсан боловч 2013 оны 7 дугаар сарын 5-ны өдөр шинэчилэн батлагдсан Цагдаагийн албаны тухай хуульд ял эдлүүлэх ажиллагаанд хяналт тавих талаар ямар нэгэн эрх зүйн зохицуулалт тусгагдаагүй байна.

Прокурорын байгууллагын тухай хуулинд хорихоос өөр төрлийн ял эдлүүлэх ажиллагаанд тавих хяналт, прокурорын үүргийг дараах байдлаар тодорхойлсон.

- Ял эдлүүлэх ажиллагаа хуульд заасан үндэслэл, журмын дагуу явагдаж байгаа эсэхэд хяналт тавих,
- Ял эдлүүлэх ажиллагааны явцад хууль зөрчсөн зөрчил, түүнд нөлөөлсөн шалтгаан, нөхцлийг арилгуулахаар шаардлага бичих

- Ял эдлүүлэх ажиллагаанд хяналт тавих чиг үүргийн дагуу хуульд заасан бүрэн эрхээ хэрэгжүүлэхдээ өөрийн эрх хэмжээний хүрээнд тодорхой асуудлыг шийдвэрлэхийн тулд тогтоол гаргах
- Ял эдлүүлэх ажиллагааны явцад хүний эрх, эрх чөлөө, хувийн болон гэр бүл, захидал харилцааны нууц, орон байр, өмчийн халдашгүй байдлыг хөндсөн ажиллагаа явуулахад прокурор бичгээр зөвшөөрөл өгөх зэрэг болно.

Цагдаагийн албаны тухай хуульд хорихоос өөр төрлийн ял эдлүүлэх ажиллагаанд хяналт тавих асуудал тусгагдаагүй бөгөөд зөвхөн ялтныг эрэн сурвалжлах, зарим төрлийн тоо бүртгэл хөтлөх эрх зүйн зохицуулалт тусгагджээ.

- Ял шийтгүүлсэн, эрүүгийн хариуцлагаас чөлөөлөгдсөн, ялаас чөлөөлөгдсөн, ялыг хойшлуулсан хүний талаар тоо бүртгэл хөтлөж, мэдээллийн сүлжээ, сан үүсгэж ажиллах
- Эрх бүхий байгууллага, албан тушаалтны даалгаснаар сураггүй алга болсон хүн, гээгдэл эд хөрөнгийг эрэн сурвалжлах зэрэг болно.

Эрүүгийн хуулинд тэнсэгдсэн ялтанд цагдаагийн байгууллага хяналт тавина гэж заасан боловч Цагдаагийн албаны тухай хуулиндаа энэ талаарх заалт байхгүй байгаа нь хуулиудын эрх зүйн зохицуулалт зөрүүтэй байгаа нь харагдаж байна.

Шүүгчийн эрх зүйн байдлын

тухай хуулинд шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн статистик мэдээлэлд хяналт тавьж, холбогдох байгууллагад шаардлага тавих үүрэгтэйг заажээ.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.3.1-д заасны дагуу эрүүгийн хэргийн талаар гарсан зарим төрлийн шийдвэрийг гүйцэтгэх ажиллагааг шийдвэр гүйцэтгэгч хэрэгжүүлж байна.

Хорихоос өөр төрлийн ял эдлүүлэх ажиллагаа түүний дотор торгох, эд хөрөнгө хураах, тодорхой албан тушаал эрхлэх, үйл ажиллагаа явуулах эрхийг хасах, албадан ажил хийлгэх ял эдлүүлэх ажиллагааны 2010 – 2013 оны бодит биелэлтийн судалгаанаас үзэхэд:

- Торгох ял – 2010 онд 35,7%, 2011 онд 55,5%, 2012 онд 58,7%, 2013 оны 10 сарын байдлаар 73,6%
- Албадан ажил хийлгэх ял – 2010 онд 87,6%, 2011 онд 90,0%, 2012 онд 92,8%, 2013 оны 10 сарын байдлаар 90,0%
- Эд хөрөнгө хураах ял – 2010 онд 42,0%, 2011 онд 49,9%, 2012 онд 52,8%, 2013 оны 10 сарын байдлаар 69,6%
- Тодорхой албан тушаал эрхлэх, үйл ажиллагаа явуулах эрхийг хасах ял – 2010 онд 20,6%, 2011 онд 26,5%, 2012 онд 3,6%, 2013 онд 34,7%-ийн бодит биелэлттэй байна.

Улсын Их Хурлын 2012 оны 37 дугаар тогтоолоор баталсан Монгол Улсын Засгийн газрын 2012 – 2016 оны үйл ажиллагааны хөтөлбөрт зааснаар “Шүүх, хууль хяналтын байгууллагын тогтолцооны шинэчлэлт хийх ажлын хүрээнд шүүхийн шийдвэр, шийдвэр

гүйцэтгэлтэй холбоотой мэдээллийг нээлттэй болгох, эрүүгийн хэргийн болон иргэний хэргийн шүүхийн шийдвэр гүйцэтгэлийг ялгавартай зохион байгуулах” бодлогыг Хууль зүйн яам, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага баримтлан ажиллаж байна.

Шинэчлэлийн Засгийн газрын бодлогод нийцүүлэн Хууль зүйн яамнаас эрх зүйн шинэтгэлийн хүрээнд боловсруулж буй Эрүүгийн тогтолцооны шинэчлэлийн багц хуулиуд түүний дотор Гэмт хэргийн тухай хуулийн төсөлд хорихоос өөр төрлийн ял оногдуулах болон тухайн ялыг эдлүүлэх талаар, ял эдлүүлэх ажиллагаанд хяналт тавих асуудлууд дараах байдлаар тусгагдан хэлэлцэгдэж байна.

Ялын бодлогыг зөөлрүүлж, хүний эрхийг дээдлэн хүндлэх зарчимд тулгуурлан эрүүгийн ялыг оногдуулахдаа хорих бус хорихоос өөр төрлийн ялыг түлхүү оногдуулах /30/70 харьцаатай/ бодлогыг баримталж төслийг боловсруулан хэлэлцэж байгаа нь өнөөгийн нийгэмд тулгамдаж буй олон асуудлыг зөв зүйтэй шийдвэрлэх боломжийг бүрдүүлсэн.

Гэмт хэргийн тухай хуулийн төсөлд гэмт хэрэг үйлдсэн хүнд оногдуулах ял, хүүхдэд оногдуулах ял, хуулийн этгээдэд оногдуулах ял гэж ангилан тэдгээрийн гэм буруугийн шинж буюу үйлдэл, эс үйлдэхүйгээс шалтгаалан тус тусд нь олон төрлийн ял оногдуулахаар хуульчилжээ.

Хорихоос өөр төрлийн ял оногдуулах бүлэг, зүйл, заалтыг Гэмт хэргийн тухай хуулийн төсөлд тусгагдсан эрх зүйн зохицуулалтын хүрээнд авч үзвэл:

*Хүнд оногдуулах ял*

1. Торгох – 18 бүлгийн 40 зүйлийн 273 заалт
2. Нийтэд тустай ажил хийлгэх – 14 бүлгийн 50 зүйлийн 53 заалт
3. Эрх чөлөө хязгаарлах – 19 бүлгийн 26 зүйлийн 177 заалт
4. Эрх хасах, хязгаарлах - байхгүй
5. Хөрөнгө, орлогыг хураах – байхгүй

Хүүхдэд оногдуулах ял

6. Нийтэд тустай ажил хийлгэх – 8 бүлгийн 15 зүйлийн 15 заалт
7. Эрх чөлөө хязгаарлах – 19 бүлгийн 26 зүйлийн 177 заалтын ял оногдуулах хэмжээг хоёр хуваасантай адил хэмжээгээр оногдуулна
- Хуулийн этгээдэд оногдуулах ял
8. Хувьцаа, хөрөнгө, орлогыг хураах – 1 бүлгийн 4 зүйлийн 4 заалт
9. Үйл ажиллагаа явуулах эрхийг тодорхой хугацаагаар хязгаарлах – 5 бүлгийн 16 зүйлийн 27 заалт
10. Үйл ажиллагаа явуулах эрхийг хүчингүй болгох – 3 бүлгийн 8 зүйлийн 9 заалт
11. Татан буулгах – 3 бүлгийн 7 зүйлийн 7 заалт.

Гэмт хэрэг үйлдсэнд нь ялын төрлүүдээс сонгон оногдуулж болохоор, зарим тохиолдолд заавал ял оногдуулах бус хянан харгалзах арга хэмжээг хэрэглэхээр хуулийн төсөлд тусгажээ.

Гэмт хэргийн тухай хуулийн төсөлд хорихоос өөр төрлийн ял эдлүүлэх ажиллагааг хэрэгжүүлэх, түүнд

хяналт тавихтай холбогдсон эрх зүйн зохицуулалт нь тодорхой бус байна. Зарим төрлийн ялыг хууль сахиулах байгууллагын хараа хяналтанд байлгаж ялыг эдлүүлэхээр дурдсан байх бөгөөд чухам Хууль сахиулагчийн эрх зүйн байдлын тухай хуулийн төслийн дагуу ямар байгууллага нь хариуцан хяналт тавих талаар мөн тусгаагүй байна.

Хууль сахиулагчийн эрх зүйн байдлын тухай хуулийн төсөлд Мөрдөх, Тахар, Цагдаа, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх, Иргэний гадаад шилжилт, харьяалал, Онцгой байдлын алба нь хууль сахиулах байгууллага мөн гэж заажээ.

Эрх зүйн шинэтгэлийн хүрээнд хууль сахиулах байгууллагуудын хуулиуд шинээр боловсрогдож байгаа өнөө үед хорихоос өөр төрлийн ялын зорилт, хэрэгжилтийг хангах, үр нөлөөг дээшлүүлэх хүрээнд доорх саналуудыг судлаачийн хувьд дэвшүүлж байна. Үүнд:

1. Удирдлага зохион байгуулалтын хүрээнд

Хууль зүйн сайдын 2013 оны 2 дугаар сарын 6-ны өдрийн А/18 дугаар тушаалаар Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын бүтцэд өөрчлөлт орж Хорихоос өөр төрлийн ял эдлүүлэх талаар гарсан шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааг хэрэгжүүлэх тусгай чиг үүрэг бүхий газар байгуулагдсан. Иймд хорихоос өөр төрлийн ял эдлүүлэх талаар гарсан шүүхийн шийдвэрийг гүйцэтгэх ажиллагааг Шийдвэр гүйцэтгэх газар буюу шийдвэр гүйцэтгэгч нар бус хорихоос өөр төрлийн ял эдлүүлэх газар, тухайн газрын алба хаагч нар хариуцан



гүйцэтгэх нь зүйтэй гэж үзэж байна.

Хорихоос өөр төрлийн ял эдлүүлэх газар нь хууль сахиулах байгууллагуудтай болоод өөрийн салбар нэгжүүдийг аймаг тус бүрд бий болгож ял эдлүүлэх ажиллагааг гүйцэтгэдэг дагнасан бүтэцтэйгээр ажиллах нь ял эдлүүлэх ажиллагааг үр дүнтэй зохион байгуулах, хуулийн хэрэгжилтийг хангахад бодитой хувь нэмэр оруулах юм.

2. Эрх зүйн зохицуулалтын хүрээнд

- ✓ Эрүүгийн ял эдлүүлэх ажиллагааг явуулж буй салбарын хууль тогтоомжинд хорихоос өөр төрлийн ял түүнийг хэрэгжүүлэх, хяналт тавих, нөхцөл, журмыг тодорхой тусгах
- ✓ Эрүүгийн ял эдлүүлэх тухай хуулинд хорихоос өөр төрлийн ялыг хэрэгжүүлээгүй нөхцөлд гэм буруутай этгээдэд хариуцлага хүлээлгэх тогтолцоо, процесс ажиллагааг тусгаж өгөх
- ✓ Хорихоос өөр төрлийн ял эдлүүлэх ажиллагаанд хяналт тавих явдалд төрийн болон төрийн бус байгууллага, орон нутгийн засаг захиргаа, хууль хяналтын байгууллагууд ямар үүрэг оролцоотой байх талаар эрх зүйн зохицуулалт оруулах нь зүйтэй гэж үзлээ.

ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ ОНОЛ-ПРАКТИКИЙН БАГА ХУРЛААС ГАРГАСАН ЗӨВЛӨМЖ

Хууль сахиулахын их сургуулийн захирал, ШШГЕГ-ын даргын хамтарсан шийдвэрээр 2013 оны 11-р сарын 20-ны өдөр “ШШГБ-ын шинэтгэл: эрх зүйн орчин, практик” сэдэвт эрдэм шинжилгээний онол практикийн бага хурал ШШГЕГ-ын хурлын танхимд зохион байгуулагдлаа.

Хуралд ШШГЕГ-ын дарга, хурандаа Д.Ядамдорж, Хууль зүйн яамны хэлтсийн дарга Г.Оюунболд болон ШШГЕГ-ын дэд дарга, мэргэжлийн албадын удирдлагууд, нийслэлийн хүрээний төвлөрсөн хорих анги, шийдвэр гүйцэтгэх албадын төлөөлөл, энэ салбарын эрдэмтэн судлаачид, ШШГС-ийн багш, сонсогчид оролцлоо.

Онол-практикийн бага хуралд судлаачдаас 21 илтгэл ирүүлснээс 4 илтгэлийг сонгон хэлэлцэж оролцогчид санал бодлоо чөлөөтэй илэрхийлсэн арга хэмжээ боллоо.

Хуралд ирүүлсэн илтгэл, оролцогчдын хэлсэн үг-санал бодолд тулгуурлан зохион байгуулагчдаас дараах зөвлөмжийг гарган ШШГЕГ, ХСИС-ийн удирдлагад хүргүүлж байна. Энэ нь:

1-рт: ШШГЕГ-ын үйл ажиллагааны

